



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/84/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn	САГСАЙ СУМЫН ХҮҮХДИЙН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ К.ЛИМАН ТАНАА
<p>2022.09.22 № 112 танай _____-ны № _____-т</p>	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p>	

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	_____ -	_____ 5,186,209.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	5,186,209.00
354	Хангамжийн материал	-	5,186,209.00
35420	Аж ахуйн материал	-	385,250.00
35440	Түлш, шатах тослох материал	-	489,704.00
35460	Хүнсний материал	-	4,311,255.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	_____ -	_____ 429,199,854.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	429,199,854.44
392	Биет хөрөнгө	-	429,199,854.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	436,440,530.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,240,675.56)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	_____ -	_____ 434,386,063.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	_____ -	_____ 3,117,440.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,117,440.00
413	Өглөг	-	3,117,440.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3,117,440.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	_____ -	_____ 431,268,623.44
51	Засгийн газрын хувь оролцоо	-	431,268,623.44
512	Хуримтлагдсан үр дүн	-	431,268,623.44
51220	Тайлант үеийн үр дүн	-	431,268,623.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	_____ -	_____ 434,386,063.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	571,604,030.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	436,440,530.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	436,440,530.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	436,440,530.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	436,440,530.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	135,163,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	134,190,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	134,190,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	156,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	156,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	816,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	816,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	140,335,406.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	140,335,406.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	138,128,349.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	102,859,047.00
210101	Үндсэн цалин	-	89,136,805.00
210104	Урамшуулал	-	6,533,932.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,188,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	13,544,096.00
210201	Тэтгэврийн даатгал	-	9,607,296.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	984,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	787,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	196,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,968,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	3,443,736.00
210302	Түлш, халаалт	-	3,443,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,839,410.00
210401	Бичиг хэрэг	-	113,900.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,339,840.00
210404	Ном, хэвлэл	-	24,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	361,170.00
2105	Нормативт зардал	-	8,469,135.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	22,000.00
210502	Хоол, хүнс	-	8,265,525.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	181,610.00
2107	Томилолт, зочны зардал	-	115,500.00
210702	Дотоод албан томилолт	-	115,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	39,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	39,250.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,818,175.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	577,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	7,240,675.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,207,057.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,207,057.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,207,057.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	431,268,623.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	431,268,623.44

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			431,268,623.44	431,268,623.44
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	431,268,623.44	431,268,623.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	135,163,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	135,163,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	134,190,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		134,190,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	156,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		156,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	816,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		816,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	135,163,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	135,163,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	132,956,443.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	102,859,047.00
210101	Үндсэн цалин		89,136,805.00
210104	Урамшуулал		6,533,932.00
210105	Гэрээт ажлын хөлс		7,188,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	13,544,096.00
210201	Тэтгэврийн даатгал		9,607,296.00
210202	Тэтгэмжийн даатгал		984,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		787,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал		196,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		1,968,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	816,600.00
210302	Түлш, халаалт		816,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,775,300.00
210401	Бичиг хэрэг		111,600.00
210402	Тээвэр, шатахуун		1,241,000.00
210404	Ном, хэвлэл		25,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		397,600.00
2105	Нормативт зардал	-	13,233,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		22,300.00
210502	Хоол, хүнс		13,029,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		181,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	111,600.00
210702	Дотоод албан томилолт		111,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	41,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		41,900.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	574,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		574,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,207,057.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,207,057.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,207,057.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,007,300.00	132,800,243.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	135,007,300.00	132,800,243.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	135,007,300.00	132,800,243.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	103,824,400.00	102,859,047.00
210101	Үндсэн цалин	89,210,600.00	89,136,805.00
210104	Урамшуулал	7,418,400.00	6,533,932.00
210105	Гэрээт ажлын хөлс	7,195,400.00	7,188,310.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,785,800.00	13,544,096.00
210201	Тэтгэврийн даатгал	10,404,800.00	9,607,296.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,095,200.00	984,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	876,200.00	787,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	219,100.00	196,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,190,500.00	1,968,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	816,600.00	816,600.00
210302	Түлш, халаалт	816,600.00	816,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,775,300.00	1,775,300.00
210401	Бичиг хэрэг	111,600.00	111,600.00
210402	Тээвэр, шатахуун	777,000.00	1,241,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	464,000.00	
210404	Ном, хэвлэл	25,100.00	25,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	397,600.00	397,600.00
2105	Нормативт зардал	13,233,200.00	13,233,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,300.00	22,300.00
210502	Хоол, хүнс	13,029,500.00	13,029,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	181,400.00	181,400.00
2107	Томилот, зочны зардал	111,600.00	111,600.00
210702	Дотоод албан томилот	111,600.00	111,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	460,400.00	460,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,900.00	41,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	418,500.00	418,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	135,007,300.00	132,800,243.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,190,700.00	131,983,643.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	134,190,700.00	131,983,643.00
132001	Орон нутгийн төсвөөс	816,600.00	816,600.00

610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	14.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	6.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13.00	14.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	5.00	5.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	6.00
650010	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	156,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	156,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	156,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	156,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		156,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	156,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	156,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		156,200.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн Аудитын газрын “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Тус цэцэрлэг нь цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгтэй холбоотой шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн

дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 66.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн нь 434.4 сая төгрөгийн ба тус цэцэрлэг нь 2021 онд шинээр байгуулагдсан байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	0.0	5186.2	5186.2
Үндсэн хөрөнгө	0.0	429199.9	429199.9
Нийт хөрөнгө	0.0	434386.1	434386.1
Өр төлбөр	0.0	3117.4	3117.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	431268.6	431268.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.0	434386.1	434386.1

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгааны данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 5.2 сая төгрөг байгаа нь аж ахуйн материал, түлш тослох материал, хүнсний материалын үлдэгдэл байна.

Төсвийн хөрөнгөөр 19.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 14.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 429.2 сая төгрөгөөр өссөн нь 436.4 сая төгрөгийн барилга байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авч, үүнд 7.2 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 431.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 431.3 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 571.6 сая төгрөг байна. Үүний 436.4 сая төгрөг буюу 76.4 хувь нь үнэ төлбөргүй хүлээж авсан үндсэн хөрөнгө, үлдсэн 23.6 хувь нь урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 138.1 сая төгрөг байгаа ба үүний 118.2 сая төгрөгөөр буюу 85.6 хувиар нь цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал ба 14.4 хувь буюу 19.9 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 146.5 сая төгрөг, тодотгосон төсөв 135.0 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөс 11.5 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Цалингийн зардлыг 6.6 сая, нормативт зардлыг 5.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс хэмнэлттэй гарах боловч хүнсний материалын үлдэгдлийг нөөцлөн хадгалсантай холбоотой хэмнэгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 135.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 134.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 134.2 сая, орон нутгийн төсвөөс 0.8 сая, нийт 134.2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 132.8 сая төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 2.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 132.8 сая төгрөг буюу 98.4 хувьтай байна.

Нийт төсвийн 77.5 хувийг цалин, 10.2 хувийг НДШ-ийн зардал, 0.6 хувийг тогтмол зардал, 1.3 хувийг хангамж бараа материалын зардал, 10.0 хувийг норматив зардал, 0.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас нийт 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч үүнийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тусгасан байна. Онцолсон хэсэгт тусгах үйл ажиллагаа байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 147 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Өр төлбөр үүсгэсэн талаарх 3.1 сая төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 3.1 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2021 оны 02 дугаар сард шинээр байгуулагдсан тул өмнөх онд аудит хийгдээгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн алдааг залруулж, 3.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 6.1 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайланд 2.2 сая төгрөгийн төвлөрүүлэн шилжүүлгийг харуулаагүйгээр санхүүжилтийг дутуу тусгасан алдааг илрүүлж, залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 3.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тус 3 дугаар цэцэрлэг нь тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд тэвчиж болох зардлын 10 хувь 0.3 сая төгрөгийн хэмнэлт тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, оны эцэст 2.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн боловч 3.1 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, өр төлбөрийг бүрэн барагдуулах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1.3 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, нярвын бараа материалын тайлангийн орлого, зарлагын анхан шатны баримтууд дутуу, бараа материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн

үлдэгдлээс 1.7 сая төгрөгөөр зөрүүтэй гаргасан зэрэг 3.0 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2010 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг	4	11.7	1	2.2			2	3.4	2	6.1

/сая төгрөгөөр/